

ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2022 оны 04 сарын 27

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурал 2022 оны 4 дугаар сарын 27 -нд Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 хороо, Санто апартмент 213 дугаар байр 1701 тоотод 14:00 цагт эхлэв.

Хуралд оролцсон:

1. Yeh Mongomer /89.6% хувьцаа эзэмшигч/
2. He Shanjun /5.0% хувьцаа эзэмшигч/
3. Ц. Оюунтуяа /5.0% хувьцаа эзэмшигч/

Хуралд байлцсан:

1. He Jingwen /Гүйцэтгэх захирал
2. Shih Pei Chin /ТУЗ-ийн гишүүн/
3. Т. Баярмаа ТУЗ нарийн бичгийн дарга

Тооллогын комисс:

1. Г. Ариунчимэг
2. З. Төгөлдөр

Энцээ! - We Chat conference call

Бүгд мөндчилэв. Гүйцэтгэх захирал He Jingwen уламжлал ёсоор орчуулга хийв.

Тооллогын комиссын дарга Ариунчимэг хурлын ирцийг мэдээлэв. Нийт 99.6 хувь буюу нийт 71,877 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг 3 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа тул хурал ирцыг бүрэн хэмээн тооцон хурлыг эхлүүлэв.

Хурлын дарга He Jingwen хурлыг нээж оролцогчдоо мөнд дэвшүүлж хурлын дэг, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. 2021 оны санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
Өнгөрсөн оны хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангууд гарч холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулсан ба Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй "Шинэ их тэрбум аудит" ХХК -ийг сонгон Компанийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан талаар хурлын дарга ярих. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ихэнх нь гадаадын иргэд, мөн дээр нь Ковидын нөлөөлөөс шалтгаалж ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл хэрэгт саадтай

байсантай холбоотой компанийн үйл ажиллагааг идэвхитэй явуулах боломж бүрдээгүй хэмээн үзэснийг танилцуулахад хувьцаа эзэмшигчид бүгд хүлээн зөвшөөрөв.

2. 2021 оны ногдол ашгийн талаарх шийдвэрийг танилцуулах

Компанийн тухай хуулийн 46.8 дах заалтыг хангахгүй байгаа буюу ашигт ажиллагаа байхгүй байгаа тул 2022 оны 02 сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн талаар хурлын дарга танилцуулав.

3. 2022 оны ТУЗ-ийн төсвийг батлах

ТУЗ-ийн зардлын төсөвт хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зардлыг 500,000 төгрөг, цалинд 3,600,000 төгрөг нийтэд нь 4,100,000 байхаар тооцсон ТУЗ-ийн шийдвэрийг хурлын дарга танилцуулав. Бүх хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

Ийнхүү хэлэлцэх асуудал өндөрлөж, хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төсөл бүрийг хурлын дарга орчуулж хэллээ. Мөн тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Хурал өндөрлөв.

ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Т. Баярмаа/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

БАТАЛСАН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ХУРЛЫН ДАРГА

/HE JINGWEN/